



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Тэшиг ус” ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: БУА-2026/07/НА-СТА-ОНӨААТҮГ

Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг 2026 он	Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Д.Батцогт Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn Ахлах аудитор: П.Мөнхтуяа Утас: 70342716 Цахим хаяг: MonkhtuyaP@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс: 7034-2580
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2026.02.04 № 295

танай _____ ны № _____ т

“ТЭШИГ УС” ОНӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ П.БАТПҮРЭВ
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Тэшиг ус” ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

“Тэшиг ус” ОНӨААТҮГ нь 2025 онд өмнөх оны үлдэгдэл 12.7 сая төгрөг, өөрийн үйл ажиллагаагаар 508.7 сая төгрөгийн орлого оруулж, нийт 521.4 сая төгрөгөөс 520.5 сая төгрөгийг зарцуулж 0.9 сая төгрөгийн үлдэгдэлтэйгээр тайлагнасан байна.

Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Тус газар нь үндсэн хөрөнгийг 3.4 сая төгрөгөөр, бараа материалыг 171.9 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлжээ.

Бусад асуудлын хэсэг

2025 онд шилэн дансанд 151 мэдээлэл тайлагнахаас 149 мэдээг хугацаанд нь мэдээлж, 2 мэдээг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТЦОГТ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

БАЛАНСЫН ЗҮЙЛ	Тодруулга	/мян.төг/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		74,310.38	37,104.12
МӨНГӨН ХӨРӨНГӨ		12,791.97	954.61
Кассанд байгаа бэлэн мөнгө		10.44	10.34
Төгрөг		10.44	10.34
Банкинд байгаа бэлэн мөнгө		12,781.52	944.27
Төгрөг		12,781.52	944.27
Арилжааны банк дахь харилцах		12,781.52	944.27
АВЛАГА		42,069.75	19,826.65
Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/		173.78	157.12
Бусад авлага		41,895.97	19,669.53
Байгууллагаас авах авлага		39,446.82	17,220.38
Хувь хүмүүсээс авах авлага		2,449.15	2,449.15
БАРАА МАТЕРИАЛ	6	19,448.66	16,322.86
Түүхий эд материал		65.00	131.82
Эм боох материал		65.00	131.82
Бэлэн бүтээгдэхүүн		4,971.00	6,918.59
Хангамжийн материал		14,412.67	9,272.45
Бичиг хэргийн материал		223.64	355.68
Аж ахуйн материал		15.30	15.30
Сэлбэг хэрэгсэл		5,419.36	629.55
Түлш, шатах тослох материал		298.18	1,709.49

Хүнсний материал		489.13	2,138.08
Бусад хангамжийн материал		7,967.05	4,424.35
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		192,072.62	161,007.05
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7	192,072.62	161,007.05
Биет хөрөнгө		191,964.62	160,899.05
Барилга, байгууламж, орон сууц		213,947.75	213,947.75
Хуримтлагдсан элэгдэл		(24,417.10)	(57,032.90)
Авто-тээврийн хэрэгсэл		50,416.67	50,416.67
Хуримтлагдсан элэгдэл		(50,416.67)	(50,416.67)
Машин тоног төхөөрөмж(компьютер)		8,637.33	12,072.06
Хуримтлагдсан элэгдэл		(7,828.33)	(8,678.57)
Тавилга, аж ахуйн эд хогшил		4,312.90	4,312.90
Хуримтлагдсан элэгдэл		(3,411.42)	(3,785.72)
Бусад үндсэн хөрөнгө		4,249.80	4,249.80
Хуримтлагдсан элэгдэл		(3,526.31)	(4,186.26)
Бусад хөрөнгө /ТӨҮГ/		108.00	108.00
Биологийн хөрөнгө /ТӨҮГ/		108.00	108.00
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2		266,383.00	198,111.17
НИЙТ ӨР ТӨЛБӨР		36,671.60	40,584.30
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		36,671.60	40,584.30
Өглөг	9	36,671.60	40,584.30
Бусад өглөг		36,671.60	40,584.30
Байгууллагад төлөх өглөг		16,027.65	40,584.30
Хувь хүмүүст төлөх өглөг		253.72	-
Татварын өглөг /ТӨҮГ/		20,390.23	-

ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		229,711.40	157,526.87
Засгийн газрын хувь оролцоо		229,711.40	157,526.87
Засгийн газрын оруулсан капитал		174,746.23	174,746.23
Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө		174,746.23	174,746.23
Хуримтлагдсан үр дүн		54,965.17	(17,219.36)
Өмнөх үеийн үр дүн		45,865.15	54,965.17
Тайлант үеийн үр дүн		9,100.02	(72,184.53)
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5		266,383.00	198,111.17

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	Тодруулга	/мян.төг/	
		Өмнөх он	Тайлант он
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	2	488,334.53	462,419.34
ТАТВАРЫН БУС ОРЛОГО		488,334.53	462,419.34
Нийтлэг татварын бус орлого		488,334.53	462,419.34
Төсөв байгууллагын өөрийн орлого		488,334.53	462,419.34
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		488,334.53	462,419.34
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3	479,234.51	534,603.87
УРСГАЛ ЗАРДАЛ		479,234.51	534,603.87
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		478,134.51	533,603.87
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		190,240.68	158,558.96
Үндсэн цалин		190,240.68	158,558.96
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		26,213.98	52,518.44
Тэтгэврийн даатгалын зардал		26,213.98	52,518.44
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		33,250.89	54,812.48
Гэрэл, цахилгаан		33,250.89	45,862.90
Түлш, халаалт		-	8,949.58
Хангамж, бараа материалын зардал		173,421.53	162,546.40
Бичиг хэрэг		1,059.69	823.30
Тээвэр, шатахуун		172,173.20	161,498.10
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		188.64	225.00
Нормативт зардал		4,155.40	6,890.82
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		17.05	151.50
Хоол, хүнс		4,138.35	6,739.32
Эд хогшил, урсгал засварын зардал		1,410.00	12,746.48
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		1,410.00	9,339.50
Урсгал засвар		-	3,406.98
Томилолт, зочны зардал		1,374.00	1,610.00
Дотоод албан томилолт		1,374.00	1,610.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		21,772.25	49,419.99

Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		4,430.14	-
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		89.00	81.59
Бусад зардал /ТӨҮГ/		16,114.24	49,338.40
Орлогын татварын зардал /ТӨҮГ/		1,138.87	-
Бараа үйлчилгээний бусад зардал		26,295.80	34,500.30
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол		26,295.80	34,500.30
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		1,100.00	1,000.00
Бусад урсгал шилжүүлэг		1,100.00	1,000.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		1,100.00	1,000.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		9,100.02	(72,184.53)
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)		9,100.02	(72,184.53)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	/мян.төг/	
	Өмнөх он	Тайлант он
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	548,908.96	508,364.28
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	548,908.96	508,364.28
Нийтлэг татварын бус орлого	548,908.96	508,364.28
Төсөв байгууллагын өөрийн орлого	548,908.96	508,364.28
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	548,831.16	508,364.28
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	77.80	-
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	548,067.42	520,201.64
УРСГАЛ ЗАРДАЛ	548,067.42	520,201.64
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	548,067.42	520,201.64
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	153,759.95	158,558.96
Үндсэн цалин	153,759.95	158,558.96
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	45,880.66	52,518.44
Тэтгэврийн даатгалын зардал	45,880.66	52,518.44
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,250.89	45,862.90
Гэрэл, цахилгаан	33,250.89	45,862.90
Хангамж, бараа материалын зардал	234,062.28	171,889.26
Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	234,062.28	171,889.26
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	65,236.39	49,458.40
Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	65,236.39	49,458.40

Бараа үйлчилгээний бусад зардал	15,877.27	41,913.68
Бараа үйлчилгээний бусад зардал	15,877.27	41,913.68
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	841.54	(11,837.36)
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	108.00	-
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	108.00	-
Дотоод эх үүсвэрээр	108.00	-
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	108.00	-
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(108.00)	-
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	733.54	(11,837.36)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	12,058.43	12,791.97
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	12,791.97	954.61

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	/мян.төг/
				Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	90,416.67	-	45,865.15	136,281.82
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(0.00)	(0.00)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	90,416.67	-	45,865.15	136,281.82
Өмчид гарсан өөрчлөлт	84,329.57	-	-	84,329.57
Тайлант үеийн үр дүн	-	-	9,100.02	9,100.02
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	174,746.23	-	54,965.17	229,711.40
2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	174,746.23	-	54,965.17	229,711.40
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	174,746.23	-	54,965.17	229,711.40
Тайлант үеийн үр дүн	-	-	(72,184.53)	(72,184.53)
2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	174,746.23	-	(17,219.36)	157,526.87

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	512,801.16	508,364.28	4,436.88	99

Татварын бус орлого	-	-	-	
Тусламжийн орлого	-	-	-	
Төсвөөс санхүүжих	512,801.16	508364.2775	4,436.88	99
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	512,801.16	521132.5951	(8,331.44)	102
УРСГАЛ ЗАРДАЛ	-	-	-	
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	512,801.16	528,998.96	(16,197.80)	103
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	-	-	
Үндсэн цалин	199,877.10	191,964.57	7,912.53	96
Нэмэгдэл	-	-	-	
Урамшуулал	-	-	-	
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,334.64	29195.15556	(5,860.52)	125
Гэрэл, цахилгаан	45,970.37	45,862.90	107.47	100
Бичиг хэрэг	822.60	981.81	(159.21)	119
Тээвэр, шатахуун	5,014.20	8,581.95	(3,567.75)	171
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	225.00	225.00	-	100
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	7,435.25	9,810.38	(2,375.13)	132
Урсгал засвар	3,373.82	2,771.00	602.82	82
Дотоод албан томилолт	2,570.00	1,610.00	960.00	63
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,680.48	11,806.20	(125.72)	101
Бараа үйлчилгээний бусад зардал	212497.705	226,190.00	(13,692.29)	106
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1		100
АЖИЛЛАГСАДЫН ТОО	18	17		94
Удирдах ажилтан	1	1		100
Гүйцэтгэх ажилтан	1	1		100
Үйлчлэх ажилтан	16	15		94

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 8.8 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс 7.8 сая төгрөгийн 1 алдааг залруулж, 0.4 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 1 албан шаардлага, 0.5 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж хүргүүлээ.

Үүнд: *Мөнгөн гүйлгээний тайланд өөрийн үйл ажиллагааны орлогыг 7.8 сая төгрөгөөр илүү тайлагнасныг НББ-ийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг*

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна.” гэсэн заалтыг үндэслэн залруулж ажиллалаа.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 0.5 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 2.9 сая төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

Аудитаар 1.0 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 1 албан шаардлага, 2 зөвлөмж өглөө.

5.1 Төлбөрийн акт

Тус газар нь 2025 онд томилолтын зардлыг олгохдоо анхан шатны баримтгүй, илүү тооцож 0.2 сая төгрөгийг олгосон.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”, 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.”, 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.”, ТБОНӨ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7-д “тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах;” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Төлбөрийн акт тогтоов.

Тус газар нь шатахууны 0.2 сая төгрөгийг анхан шатны нотлох баримтгүй, шууд зардлаар бүртгэж зарцуулсан.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”, 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.”, 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.”, ТБОНӨ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7-д “тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах;” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

“Тэшиг ус” ОНӨААТҮГ нь 2025 онд байгууллагын төсөв хөрөнгөтэй холбоотой 9.8 сая төгрөгийн 12 тушаал, шийдвэрийг шилэн дансанд мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ.”, 6 дугаар зүйлийн 6.4.8-д “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Албан шаардлага тогтоов.

5.3 Зөвлөмж

1. Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Хүчингүй болсон дотоод журмын заалтыг үндэслэн 0.5 төгрөгийг шагнал урамшууллын зардалд зарцуулсан.

Өгсөн зөвлөмж:

Цаашид төсөв, хөрөнгөтэй холбоотой тушаал, шийдвэрийн үндэслэл, заалтыг зөв оруулж ажиллах.

2. Шилэн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Хагас жилийн санхүүгийн тайлан, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан гэсэн 2 мэдээг хугацаа хоцроож мэдээлсэн.

Өгсөн зөвлөмж:

Цаашид Шилэн дансанд мэдээлэх мэдээллийг хугацаанд нь бүрэн оруулж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Орлого илүү тусгасан.	1	7,857.6			1	7,857.6	1	7,857.6				
Дүн	1	7,857.6			1	7,857.6	1	7,857.6				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Томилолтын зардлыг АШБ-гүй илүү олгосон.	1	220.0	1	220.0								
Шатахууны зардлыг АШБ-гүй шууд зардлаар зарцуулсан.	1	215.9	1	215.9								
Хүчингүй заалтаар зардал гаргаж зарцуулсан.	1	500.0					1	500.0				
Дүн	3	935.9	2	435.9			1	500.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Төсөвтэй холбоотой мэдээллийг мэдээлээгүй.	1	0			1	0		
Мэдээллийг хугацаанд нь мэдээлээгүй.	1	0					1	0
Дүн	2	0			1	0	1	0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	2	0			1	0	1	0